

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ЯВДЛЫН ЯАМНЫ ДӨРӨВ ДЭХ САЙД САНЖИЙН ГИВААБАЛЖИР ГЭЖ ХЭН БЭ?

*Д.Доржготов**

Гурван төрийн нүүр үзэхдээ хоёрт нь алба хашиж байсан Санжийн Гиваабалжир 1891 оны луу жил Сайн ноён хан аймгийн Пүрэв гүний хошуу одоогийн Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын нутаг Мөрөн гэдэг газар (улзан) Санжийн нэгдүгээр хүү болон төржээ.

С.Гиваабалжир багын сэргэлэн цовоо, аливаа зүйлийг ой тойндоо тусган авахдаа авхаалжтай хүүхэд байжээ. Тэднийх угийн ядуу айл байсан тул хошуу ноён Пүрэвжавын авга ах Дандгай тайжийнд гэр бүлээрээ зарцлагдан малыг нь маллаж байхдаа хуучин монгол бичгийг гэрээр заалган суралцаж, Хэвт ёсны 11 он, Европын 1908 оны хоёрдугаар сард Сайн ноён хан аймгийн Загийн голын Биндэрьяа нуурын чуулган даргын газарт байгуулагдсан монгол, манж хэл бичгийн тэнхимд орж суралцан бичиг үсэг, манж хэлэнд сайн гэгдэж нутаг хошуундаа нэрд гарсан байна.

С.Гиваабалжир 1911 оноос Наран хутагтын шавь Пүрэв гүний хошууны Тамгын газар тал, бүтэн бичээч хийж байгаад ардын хувьсгалтай золгож Хүрээмарал уулын хошууны туслах, захирагч, түшмэл, худалдааны төлөөлөгч, Улиастайд суух Засгийн газрын баруун таван аймгийн шашны төлөөлөгч, аймагтаа Засгийн газрын төлөөний түшмэл зэрэг ажлыг хийж байжээ.

Тэрээр 1923 онд Хүрээмарал уулын хошууны 57 дугаар үүрт намын гишүүнээр элсэж, тэр жилдээ Цэцэрлэг Мандал уулын аймгийн анхдугаар хурлаар Захиргааны зарга шийтгэх хэлтсийн даргаар сонгогджээ.

С.Гиваабалжир Улсын I, II, III, IV их хуралд төлөөлөгчөөр сонгогдон оролцсон төрийн анхны зүтгэлтнүүдийн нэг бөгөөд II хурлын дэд даргаар сонгогдон хурал удирдаж байжээ.

БНМАУ-ын Бага хурлын 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн анхдугаар хурлын 15 дугаар тогтоолын зургадугаар зүйлд Бага хурлын гишүүнээр 30 хүн сонгогдоход С.Гиваабалжир оржээ. Мөн сарын 29-ний өдрийн хурлын нэгдүгээр тогтоолын тавдугаар зүйлд БНМАУ-ын Гадаад явдлын яамны (дөрөв дэх) сайдаар С.Гиваабалжирыг баталжээ.

Монгол улсын нэрт удирдагч Б.Цэрэндорж, А.Амар зэрэг хашир туршлагатай чадварлаг олон хүмүүст үнэлэгдэн шалгарч

* Д.Доржготов - яруу найрагч

тэр үеийн ГЯЯ-ны сайдаар томилогдож байсныг бодоход манай улсын гадаад харилцааг эрхлэн явуулж чадах улс төрийн бодлого, алсын хараатай, ажлын туршлагатай, бичиг үсгийн чадвар сайтай том сэхээтний нэг байсан нь тодорхой байна.

БНМАУ-ын Засгийн газрын эрхлэх товчооны 1925 оны арван нэгдүгээр сарын 25-ны өдрийн 145 дугаар хурлаар ард олны саналыг хэлэлцэн ёсоор болгож, С.Гиваабалжирыг Цэцэрлэг Мандал уулын аймгийн Ерөнхий даргаар сонгон баталснаар Улсын бага хурлын гишүүн, ГЯЯ-ны сайдаас чөлөөлжээ.

С.Гиваабалжир нь ГЯЯ-ны 1925 оны тайлан илтгэлдээ: “Зөвлөлт Холбоот Улстай найрамдлаа улам зузаатгах ба бусад гадаад олон улсаас найрамдваас зохих улсууд лугаа харилцан найрамдаж, улс төр ба ард түмэнд тустай хэргийг явуулж, гадаад улсын төлөв байдлыг засгийн газраа нэвтрүүлж байхыг эрхэмлэн Дундад иргэн улсын олон түмэн лугаа холбоо найрамдлыг байгуулах ба бүх монгол угсаатан дор эрх чөлөө олгох хэргийг цаг тухайн байдалд нийцүүлж оролдвоос зохино” гэжээ.

Үүнээс үзэхэд сайд С.Гиваабалжир улсынхаа тусгаар тогтнолыг бэхжүүлэх, түүний олон улсын нэр хүндийг өсгөх, улс түмний найрамдлыг хөгжүүлэхэд юуны өмнө хоёр их хөрш Орос, Хятадын ард түмэнтэй найрсгаар харилцаж, хамтын ажиллагааг хөгжүүлэхийг чухалчилж байжээ.

С.Гиваабалжир 1933 онд гэр бүлээрээ хөдөө гарч, мал маллан амьдарч байтал дахин дуудагдаж, 1934 оноос аймагтаа Засгийн газрын Онц бүрэн эрхт төлөөлөгчөөр томилогдон ажилласан байна.

Түүхэн баримтаас үзэхэд С.Гиваабалжирт монгол бичиг үсэг заан зарцалж байсан Пүрэв гүний хошууны ноён Пүрэвжавын авга ах Дандгай тайж нас барахдаа өөрийн бага хатан Бадамыг хүчээр эхнэр болгон өгч суулгажээ. Дандгай тайжийн бага хатан Бадамаас хүүхэд гараагүй байсан бөгөөд С.Гиваабалжиртай суугаад Балганжав, Ажгаа, Паартуу гэх 3 хүү, Нямсүрэн гэдэг ганц охин төржээ.

С.Гиваабалжир Улиастайд суух баруун таван аймгийн шашны төлөөлөгч, Цэцэрлэг Мандал уулын аймгийн Зарга шийтгэх хэлтсийн дарга мөн аймгийн Ерөнхий дарга зэрэг ажил хийж байхдаа одоогийн Баянхонгор аймгийн Гурванбулаг суманд байсан 4 хүүхэдтэй эхнэр дээрээ бараг очдоггүй, ганцаараа явж алба ажлаа хийдэг хүн байжээ. Үүний шалтгааныг судлахад нутгийн өндөр настай хүмүүс болон хүү Балганжав, Паартуу

нарын ярианаас үзвэл Гиваабалжир нь хошууны том толгой баян тайжийн авгайтай сууснаасаа болоод ичсэн зовсон ч байж болох юм. Нөгөө талаар нударган баян гэж тооцогдохоосоо эмээж татгалзсан ч байж болох юм гэж хэлж байжээ.

С.Гиваабалжир Гадаад явдлын яамны сайд байхдаа бүх цэргийн жанжин маршал Дэвид, Дотоод явдлын яамны сайд Намсрай нартай ойр дотно үерхэж, хошин шог яриа дэлгэн, инээж наргиж явдаг хүн байсан байна. Ийм ч учраас Гиваабалжирын отгон хүү Паартууг Дэмидийнх хүүгүй учир үрчлэн авахаар тохирч лам нараар үзүүлэхэд Паартууг долоон нас хүрэхээр нь ав гэж шоо төлгөнд нь буужээ. Гэтэл Дэмидийнх Паартууг өргөн авч чадалгүй улс төрийн хилс хэрэгт холбогдон баривчлагдсан байна.

1930-аад онд улсыг батлан хамгаалах, мөн Зөвлөлт Орос улсаас нисэх онгоц авах зэрэгт ард түмнээс хэд хэдэн удаа хөрөнгө цуглуулахад С.Гиваабалжир өөрийнхөө алт, мөнгөн хоёр аяганы нэгэнд нь сүү, нөгөөд нь тараг хийж гэрт байгаа хүмүүст тойруулан амсуулж, хоёр аягаа тус бүрийг луун хээтэй шар торгон уутанд хийж зааны яс, ундрам шахуургаар шахаж баранзад хадганд ороогоод өргөл болгон өгч байжээ. Нэг хүү нь алтан аягаа өгөхгүй гэхэд, Гиваабалжир “Өгөлгүй яахав, тэр онгоцонд чинь та нар болон та нарын үр хүүхэд суух юм шүү. Энэ онгоц чинь нийгэм журмын хурдан хүлэг юм шүү” гэж хэлж байгаад өгч байжээ.

Мөн эх орноо хамгаалах хүч чадлыг бэхжүүлэхийн тулд ардын улаан цэрэгтээ туслахад тэрбээр 100 эр хонь бэлэглэснийг Гурванбулаг сумын ард Ж.Дамдин тууварлан хүргэж өгсөн байна. Мөн ардууд мөнгөн тусламж өгөхөд 100 төгрөг тусалсан цөөн тооны хүмүүсийн дотор С.Гиваабалжир оролцсон байна.

С.Гиваабалжирын түүхт үйл амьдралын тухай Баянхонгор аймгийн улсын архивын фондод байгаа баримт сэлтийг нягтлан үзвээс сонирхол татахуйц зарим зүйл байгааг орхигдуулж болмооргүй санагдана. Энэ тухай доор өгүүлэхэд: 1976 онд Гурванбулаг сумын Хоёрдугаар бригадын малчин Шагдарын Шархүү Улаанбаатар хотод ирж эмчлүүлээд нутаг буцах гэж байхдаа одоогийн Гэсэр сүмийн зүүн урд Урт цагааны зах дээр явж байгаад Гиваабалжирын хөтөч байгаад хамт баригдсан Бэгзжавтай тааралдан уулзжээ. Бэгзжав нутгийн өвгөн Ш.Шархүүд ярихдаа “Би оросын буриад авгай авсан. Гиваабалжир 1938 онд шоронгоос суллагдаж, нутагтаа ямар нүүрээрээ очих юм гэж хэлээд Улаан-Үд хотод очиж түүхийн

манж, монгол, орос хэлний орчуулагчаар ажиллаж байгаад 1963 онд шиг санаж байна нутаг орноо бараадъя гэж хэлээд Алтанбулаг хотод ирж жирийн амьдарч байгаад 1965 онд 74 настайдаа нас барсан” гэж ярьжээ. Энэ нь албан бус боловч сонирхолтой баримт юм.

“С.Гиваабалжир эх оронч сэтгэлтэй, шударгуу үнэнч, хүнд тусархуу, том сайхан биетэй, шатарт дуртай, сур сайхан харвадаг, улсын мэргэн цолтой хүн байсан” хэмээн түүнийг сайн таних Архангай аймагт суудаг Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн Гантөмөр гуай дурсан ярьж байжээ.

1930-1940-өөд оны завхарлын үед С.Гиваабалжирыг хэд хэдэн удаа баривчлан хорьжээ. Гиваабалжир Жонон гүний хошууны занги, залан, захирагч тушаалыг арав шахам жил хийж явсны дараа 1932 онд улс төрийн цуурхал гаргаж, нийтийн сэтгэл санааг үймүүлсэн хэмээн баригдаж, долоон сар мөрдөгдөөд нийтийн өршөөлдөөр суллагдсан юм. Энэ нь түүний ард түмний дунд хэчнээн их нэр хүндтэй, олны сэтгэл зүрхийг эзэмдсэн хүн байсныг тодорхой гэрчилж байна.

Долдугаар Богдын Нойчин Сулив гэдэг номыг Довдон гавжаас авч тараасан хэмээн 1938 оны зургадугаар сарын 20-нд баригдаж долдугаар сарын 7-нд Бүрэн эрхт онцгой комиссын зургадугаар тогтоолоор дээд хэмжээгээр шийтгэгджээ.

Гэвч Гиваабалжирын гэмт хэрэг гэгч нь ор үндэсгүй тул 1992 оны тавдугаар сарын 20-нд БНМАУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллегийн 77 дугаар магадлалаар цагаатгаж нэр төрийг нь сэргээсэн юм.